

# Сүнсний дэлхий

Алма 40:6–7, 11–14-ийг уншаад, Алма Кориантонд юу заасныг үз. Дараа нь юу заахаа бэлдэхэд тань туслах дараах эх сурвалжуудыг ашигла.

Сургаал ба Гэрээ 138:11–13, 18–22, 57

Судруудын удирдамж, “Диваажин,” [scriptures.ChurchofJesusChrist.org](http://scriptures.ChurchofJesusChrist.org)

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Даллин Х.Өүкс ийн заасан.



Бие махбод маань үхсэний дараа ч гэсэн бид сүнсний дэлхийд сүнс болж, үргэлжлүүлэн амьдарна гэдгийг бид судраас мэддэг. Сүнсний дэлхий нь амьдралынхаа туршид “зохистой” буюу “зөв шударга” байсан хүмүүс ба ёс бус байсан хүмүүсийн хооронд хуваагдсан байдаг гэж судрууд бидэнд заадаг. Мөн зарим итгэлтэй сүнс сайн мэдээг ёс бусчуудад, мөн дуулгаваргүй байсан хүмүүст заана гэдгийг тайлбарладаг (1 Петр 3:19; Сургаал ба Гэрээ 138:19–20, 29, 32, 37-г үзнэ үү). (Даллин Х.Өүкс, “Эзэнд итгэ,” 2019 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 27)

Дараах асуултуудын хариултыг хэрхэн тайлбарлахаа бэлд.

- Биднийг нас барахад бидний сүнсэнд юу тохиолдох вэ?
- Диваажинд ямар байх вэ? Алмагийн “гадаад харанхуй” гэж нэрлэдэг сүнсний шорон (1 Петр 3:19) эсвэл там (2 Нифай 9:12) гэдэг газар ямар байдаг вэ?
- Диваажин, шорон хоёрын талаар суралцах нь бидний Аврагчид талархах талархлыг хэрхэн нэмэгдүүлэх вэ?
- Бидний сүнсний дэлхийн мэдлэг мөнх бус амьдралын туршид хэрхэн биднийг адислах вэ?

Заахдаа үхэл, амилуулалт хоёрын хооронд зөв шударга сүнснүүд диваажинд, ёс бус сүнснүүд сүнсний шоронд байх болно гэдгийг ойлгомжтой байхад анхаар. Энэхүү үнэний тухай ойлголт тань энэ амьдралд хийсэн сонголтуудад тань хэрхэн нөлөөлсөн тухай хуваалц.